



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 5/84

Чингис хот

**С.Энхтогоог хөдөлмөрийн гэрээгээр
ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1, 112.2, 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн М.Дэлгэрзаяа нь Улаанбаатар хотод төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байгаад хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоосны улмаас ирэх боломжгүй болсон тул Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.5.1, 8.5.2 дахь заалтын дагуу 2021 оны төсвийн төслийг хугацаанд нь гүйцэтгэх шаардлагатай байгааг харгалзан үзэж тус мэргэжилтний албан үүргийг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл хугацаанд С.Энхтогоог хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсугай.

2. С.Энхтогоогийн цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу 680286 /зургаан зуун наян мянга хоёр зуун наян зургаа/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР